



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2018



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

Танилцуулгыг хянасан:

Д.Мөнхзул

ЧДС-ийн хэлтсийн дарга

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

З.Оюундарь

ЧДС-ийн хэлтсийн мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,

Нийслэлийн Засаг захиргааны 3-р байр

Утас: 70130767, 70110767, 11-310767

И-мэйл: chingeltei@nso.mn

Цахим хаяг: www.ubstat.mn, chingeltei.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	5
ОРШИЛ	6
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ	7
I. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	8-9
II. ХАМРАХ ХҮРЭЭ	10
III. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	11-19
ДҮГНЭЛТ	20
ХАВСРАЛТ.....	21-22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Байгууллагын нэрийн өөрчлөлт

Хүснэгт 2. Эрүүл мэндийн байгууллагын тоо, тээвэр, тоног төхөөрөмжийн хангамж, 2018 он

Хүснэгт 3. Эрүүл мэндийн ажиллагчдын тоо, 2018 он

Хүснэгт 4. Дүүргийн эрүүл мэндийн салбарын үзүүлэлт, 2014-2018 он

Хүснэгт 5. Бүртгэгдсэн халдварт өвчин, 2016-2018 он

Хүснэгт 6. Хүүхдийн өвчлөл, насны ангиллаар, 2018 он

Хүснэгт 7. Хүүхдийн өвчлөл, хороодоор, 2018 он

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эрүүл мэндийн салбарын ажиллагчдын тоо, 2018 он

Зураг 2. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн өвчтөн, 2014-2018 он

Зураг 3. Бүртгэгдсэн өвчлөл, 2016-2018 он

Зураг 4. Нас баралт, нялхсын эндэгдлийг харьцуулахад, 2011-2018 он

Зураг 5. Төрсөн эх, амьд төрсөн нярайг эндсэн эх, нялхсын эндэгдэлтэй харьцуулахад,
2011-2018 он

Зураг 6. Нийт төрөлт болон нас баралт, 2011-2018 он

Зураг 7. Хүүхдийн өвчлөл, насны ангиллаар, 2018 он, хувиар

Зураг 8. Хүүхдийн өвчлөл, хороодоор, 2018 он

ОРШИЛ

Монгол Улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн хэлбэртэй байгууллагуудаас бүрдэнэ.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого”, “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого – 2030”, “Эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичгүүдэд эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг хамгийн чухлаар авч үзэж буй хэдий ч сүүлийн жилүүдэд хүүхдийн эндэгдэл, өвчлөл, бусад эрүүл мэндийн үзүүлэлт нь төдийлөн сайжрахгүй байгаа нь үзүүлэлтүүдээс харагдаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв Сүхбаатарын районы АДХГЗ-ны 1985 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 20 дугаар тогтоол, Улаанбаатар хотын АДХГЗ-ны эрүүлийг хамгаалах газрын захиргааны зөвлөлийн 1985 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн өргөтгөсөн хурлын шийдвэрээр анх Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг нэртэйгээр байгуулагдсан байна.

Улсын их хурлын 1992 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчлөн Сүхбаатар район нь Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг болон салсан байна. Мөн 1992 оноос Улаанбаатар хотын 4 дүгээр нэгдсэн эмнэлэг нэртэйгээр ажиллаж байгаад Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан 1997 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08, А/06 дугаар шийдвэрээр Чингэлтэй эрүүл мэндийн нэгдэл болон зохион байгуулагдсан.

Улмаар Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2014 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/82 тоот тушаалын дагуу Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв болон үйл ажиллагаагаа явуулж байгаа төрийн өмчит үйлчилгээний байгууллага юм.

Хүснэгт 1. Байгууллагын нэрийн өөрчлөлт

Д/д	Огноо	Нэрийн өөрчлөлт
1	Сүхбаатарын районы АДХГЗ-ны 1985 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 20 дугаар тогтоолоор	Сүхбаатар районы нэгдсэн эмнэлэг
2	БНМАУ-ын Эрүүл мэндийн сайдын болон Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны хамтарсан 1991 оны А/39/82 тогтоолоор	Сүхбаатар районы нэгдсэн эмнэлэг (Нэгдсэн IV эмнэлэг) Улаанбаатар хотын Эрүүл мэндийн төв №1 Улаанбаатар хотын Эрүүл мэндийн төв №2 Улаанбаатар хотын Эрүүл мэндийн төв №3
3	Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан 1997 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08, А/06 дугаар шийдвэрээр	Чингэлтэй эрүүл мэндийн нэгдэл
4	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2014 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/82 дугаар тушаал	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв

I. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Эрүүл мэндийн статистикийн тухай ойлголт:

Монгол Улсын “Эрүүл мэндийн тухай” хуульд “эрүүл мэнд” гэж хүн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байх”-ыг хэлнэ гэж тодорхойлжээ.

Эрүүл мэндийн статистик:

1) Эрүүл мэндийн статистикт хүн амын эрүүл мэндийн төлөв байдал, түүний дотор өвчлөлтэй холбоотой бүх мэдээллийг багтаан ойлгох бөгөөд төрөлт, нас баралт, түүний шалтгаан, эрүүл мэндийн үйлчилгээний талаарх мэдээллийг багтаадаг.

2) Амьдралын хэв маяг, нийгэм, эдийн засгийн байдлын гэх зэрэг мэдээллүүдийг эрүүл мэндийн болон өвчлөлийн байдалд нөлөөлдөг эрүүл мэндийн статистикт хамаарах үзүүлэлтүүд гэж үздэг.

3) Эрүүл мэндийн байдалтай нягт холбоотой хүн амын тоо, шинж чанарын талаарх статистик мэдээлэл нь эрүүл мэндийн статистикийн суурь мэдээлэл болдог.

Эрүүл мэндийн статистикийн үүрэг:

1) Хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны талаарх мэдээлэл нь өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний суурь мэдээлэл болдог.

2) Өвчлөл, төрөлт, нас баралтын шалтгаан, эмнэлгийн тоо, их эмч, сувилагчийн тоо гэх мэт эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд нь эрүүл мэндийн үйл ажиллагааны үр ашиг, өгөөж, чанарын талаарх бодит дүр зургийг харуулдаг.

3) Эрүүл мэндийн статистик нь хүн амын эрүүл байж, урт наслалтыг дэмжихэд чиглэсэн мэдээлэл болдог.

Эрүүл мэндийн статистикийн төрөл:

Эрүүл мэндийн статистикийг дараах 4 ерөнхий төрөлд хуваадаг.

- 1) Өвчлөлийн статистик
- 2) Нас баралтын статистик
- 3) Эрүүл мэндийн үйлчилгээний нөөцийн статистик
- 4) Хоол тэжээл, амьдралын хэвшлийн статистик

Эрүүл мэндийн статистикийн ангилал, аргачлал:

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын статистикийн ангиллын хувьд 1996 он хүртэл ӨОУА-9, 1997 оноос “ӨОУА-10” (2008 онд шинэчлэгдсэн), 2013 онд нэвтрүүлж буй “ҮОУА-9” (2008 он)-ыг ашиглаж байна.

Эрүүл мэнд, нөхөн үржихүйн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг олон улсын нийтлэг аргачлалд нийцүүлж хамгийн сүүлд ҮСХ-ны даргын 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/151 тоот тушаалаар шинэчлэн баталсан.

Эрүүл мэндийн албан ёсны статистикийн үзүүлэлт:

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүн ам, нийгмийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлсон бөгөөд уг хуулийн дээрх хэсгийн 3/-д Хүн амын эрүүл мэнд, эмнэлэг, эмч, өвчлөгчдийн тоо гэсэн үзүүлэлтүүдийг гаргаж байхаар заасан.

Энэхүү үзүүлэлтэд эрүүл мэндийн дараах үзүүлэлтийг оруулсан.

- Төрсөн хүүхэд, амаржсан эх
- Эх, хүүхдийн эндэгдэл
- Нас баралт, шалтгаанаар
- Халдварт өвчнөөр өвчлөгчид
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид
- Хорт хавдраар өвчлөгчид, нас баралт
- Үр хөндөлтийн тоо
- Жирэмсэн эмэгтэйчүүдийн эмнэлгийн хяналтад хамрагдалт
- Нэг хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалтын хамралт
- Сүрьеэгийн өвчлөл, тархалт, нас баралт
- 15-24 насны залуучууд, жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах ХДХВ-ын халдварын тархалт
- Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид, мэргэжлийн чиглэлээр
- Эрүүл мэндийн байгууллага, орны тоо
- Эрүүл мэндийн салбарын зардал

II. ХАМРАХ ХҮРЭЭ

Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг "Төв", "Бага тойруу", "Хайлааст", "Хайлааст хүүхэд" салбар амбулаториуд, 272 ор бүхий "Нэгдсэн эмнэлэг"-ээр дамжуулан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүн ам, нийгмийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлсон бөгөөд уг хуулийн дээрх хэсгийн 3/-д Хүн амын эрүүл мэнд, эмнэлэг, эмч, өвчлөгчдийн тоо гэсэн үзүүлэлтүүдийг гаргаж байхаар заасан.

Энэхүү эрүүл мэндийн албан ёсны статистик үзүүлэлтэд эрүүл мэндийн дараах үзүүлэлтийг оруулсан.

- Төрсөн хүүхэд, амаржсан эх
- Эх, хүүхдийн эндэгдэл
- Нас баралт, шалтгаанаар
- Халдварт өвчнөөр өвчлөгчид
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид
- Хорт хавдраар өвчлөгчид, нас баралт
- Үр хөндөлтийн тоо
- Жирэмсэн эмэгтэйчүүдийн эмнэлгийн хяналтад хамрагдалт
- Нэг хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалтын хамралт
- Сүрьеэгийн өвчлөл, тархалт, нас баралт
- 15-24 насны залуучууд, жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах ХДХВ-ын халдварын тархалт
- Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид, мэргэжлийн чиглэлээр
- Эрүүл мэндийн байгууллага, орны тоо
- Эрүүл мэндийн салбарын зардал

III. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Чингэлтэй дүүрэгт 2018 онд төрийн нэгдсэн 1, өрхийн эрүүл мэндийн 16 төв нийт 19 нэгжид 208 эмч, ажилтнууд ажиллаж, дүүргийн иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. Эмнэлгийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг Төв эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг, Бага тойруу салбар, Хүүхдийн амбулатори, Хайлааст салбаруудаар дамжуулан хүргэж байгаа бөгөөд эдгээрт 357 эмч, ажилтан албан хаагчид ажиллаж байна.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн байгууллагын тоо, тээвэр, тоног төхөөрөмжийн хангамж, 2018 он

Эрүүл мэндийн байгууллагууд		Байгууллагын тоо				Автомашины тоо		Компьютерийн тоо		Хэвлэгчийн тоо		Хувилагчийн тоо		Засвар хийгдсэн эмнэлэг			
						Бүгд		Бүгд									
		Түргэн тусламжийн Үүнээс: Ажиллаж байгаа				Бүгд Үүнээс: Ажиллаж байгаа		Интернэтэд холбогдсон байгууллагын тоо		Бүгд Үүнээс: Ажиллаж байгаа		Телефон утасны тоо				Бүгд Үүнээс: Ажиллаж байгаа	
		Бүгд		Өрхийн эрүүл мэндийн төв		Бүгд		Дүүргийн нэгдсэн эмнэлэг		Нийт дүн							
Анхдагч шатлалын эмнэлгүүд	Бүгд	16	20	-	15	130	122	16	67	64	17	41	38	6			
	Өрхийн эрүүл мэндийн төв	16	20	-	15	130	122	16	67	64	17	41	38	6			
Хоёрдогч шатлалын эмнэлгүүд	Бүгд	1	4	2	3	205	142	1	53	47	46	15	11	1			
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	1	4	2	3	205	142	1	53	47	46	15	11	1			
Нийт дүн		17	24	2	18	335	264	17	120	111	63	56	49	7			


Дүүргийн иргэдэд эрүүл мэндийн салбарын үйлчилгээг 17 эмнэлгийн байгууллагын 565 мэргэжилтнүүд үзүүлсэн байна. Тухайлбал, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн 24, эм зүйч 3, их эмч 177, сувилагч 187, эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан 35, мэдээллийн технологийн инженер 4, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер 2, бусад дээд мэргэжилтэн 28, бусад ажилтан 98 ажиллаж, ард иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлжээ.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн ажиллагчдын тоо, 2018 он

Үзүүлэлт	Ажиллагчдын тоо	Үүнээс: Эмэгтэй
Бүгд	565	494
Удирдах ажилтан	9	2
НЭМ-ийн мэргэжилтэн	24	19
Үүнээс: Статистикч их эмч	-	-
Эм зүйч	3	3
Био анагаахын мэргэжилтэн	-	-
Их эмч, бүгд	177	154
Хүний их эмч	166	145
Уламжлалт анагаахын их эмч	4	4
Нүүр амны их эмч	7	5
Сувилагч, бүгд	187	184
Эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, бүгд	35	34
Эх баригч	-	-
Багийн бага эмч	-	-
Бусад бага эмч	-	-
Лаборант	13	12
Техникч	4	4
Эм найруулагч	3	3
Бусад	15	15
Мэдээллийн технологийн инженер	4	3
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	2	-
Бусад дээд мэргэжилтэн	28	22
Бусад ажилтан	96	73

Эрүүл мэндийн ажиллагчдын 177 их эмч байгаагаас анхдагч шатлалын эмнэлэгт буюу өрхийн эрүүл мэндийн төвд 78, хоёрдогч шатлалын эмнэлэгт буюу дүүргийн нэгдсэн эмнэлэгт 99 хүн ажиллаж байна.

Зураг 1. Эрүүл мэндийн салбарын ажиллагчдын тоо, 2018 он




Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 690546 үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30837 (4.3%)-аар буурсан байна. Үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 41.9 хувийг, амбулаторийн үзлэг 27.7 хувийг, диспансерийн идэвхтэй хяналтын үзлэг 12.9 хувийг, гэрийн идэвхтэй үзлэг 17.1 хувийг, гэрийн дуудлагын үзлэг 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4. Дүүргийн эрүүл мэндийн салбарын үзүүлэлт, 2014-2018 он

Үзүүлэлтүүд		2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	Хувь	Зөрүү
Нийт үзлэг		732 244	762 515	787 144	721 383	690 546	-4.3	-30 837
Үүнээс:	Урьдчилан сэргийлэх	301 619	296 465	302 222	283 688	289 681	2.1	5 993
	Амбулаторит	201 308	216 690	233 541	199 700	190 937	-4.4	-8 763
	Диспансерийн идэвхтэй хяналт	84 730	95 525	96 935	90 865	89 275	-1.7	-1 590
	Гэрийн идэвхтэй үзлэг	139 838	149 137	149 863	138 389	117 945	-14.8	-20 444
	Гэрийн дуудлагын үзлэг	4 749	4 698	4 583	8 741	2 708	-69	-6 033
Аймаг, дүүргийн НЭ		246 423	242 722	269 599	241 737	248 210	2.7	6 473
Өрхийн эмчийн үзлэг		485 821	519 793	517 545	479 646	442 336	-7.8	-37 310
Бүртгэгдсэн өвчлөл		29 803	36 123	45 848	54 460	37 510	-31.1	-16 950
Үүнээс:	Шинэ	16 737	23 646	29 707	36 682	25 488	-30.5	-11 194
	Хуучин	13 066	12 477	16 141	17 778	12 022	-32.4	-5 756
Шинээр бүртгэгдсэн хорт хавдар		42	45	82	59	71	20.3	12
Шинээр бүртгэгдсэн осол гэмтэл		609	493	384	23	30	30.4	7
Хэвтсэн өвчтөн		10 576	9 790	10 670	10 469	10 908	4.2	439
Эмнэлгийн нас баралт		39	38	46	54	59	9.2	5
Хоног болоогүй нас баралт		14	18	10	15	20	33.3	5
Задлан шинжилгээнд орсон		29	28	29	31	33	6.4	2
Эмчлэгдсэн өвчтөн		10 552.0	9 796.5	10 628.5	10 514.0	10 895.5	3.6	381.5


Харин эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо өмнөх оноос 439 (4.2%)-аар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн өвчтөн, 2014-2018 он



Дүүргийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт бүртгэгдсэн өвчлөл 37510 байгаагаас нийт халдварт өвчин 2061 (5.5%) –г эзэлж байна.

Зураг 3. Бүртгэгдсэн өвчлөл, 2016-2018 он




Нийт халдварт өвчинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 552 (21.1%)-аар буурсан нь улаан эсэргэнэ, бруцеллёз, гар, хөл, амны өвчин, эритема түс түс буурсан нь нөлөөлж байна. Харин цочмог халдварт өвчин нийт халдварт өвчний 41.3 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 42 (4.6%)-аар буурсан байна.

Хүснэгт 5. Бүртгэгдсэн халдварт өвчин, 2016-2018 он


Үзүүлэлтүүд	2016	2017	2018	Хувь	Зөрүү
Нийт халдварт өвчин	4 213	2 613	2 061	-21.1	-552
Гепатит	30	27	22	-18.5	-5
Цусан суулга	297	370	513	38.6	143
Сальмонеллез	16	18	26	44.4	8
Хоолны хордлого	93	10	27	170.0	17
Менингит	0	1	3	200.0	2
Салхин цэцэг	323	523	369	-29.4	-154
Гахайн хавдар	21	10	14	40.0	4
Улаан эсэргэнэ	131	150	67	-55.3	-83
Ёлом	13	20	16	-20.0	-4
Бруцеллёз	1	2	1	-50.0	-1
Гар, хөл, амны өвчин	396	472	145	-69.3	-327
Эритема	14	8	2	-75.0	-6
Хачигт риккетсиоз	7	1	4	300.0	3
Улаан бурхан	1758	0	0	0	0
Спирохертээр сэдээгдсэн бусад халдвар	1	2	0	-100.0	-2
Exanthema subitum B08.2	15	103	0	-100.0	-103
Энтеровируст цэврүүт фарингит	1	2	0	-100.0	-2
Тэмбүү	465	336	285	-15.2	-51
Төрөлхийн тэмбүү	3	1	4	300.0	3
Заг хүйтэн	151	126	149	18.3	23
Сүрьеэ	326	257	263	2.3	6
Мөөгөнцөр	37	30	29	-3.3	-1
Трихомониаз	116	145	123	-15.2	-22
ХДХВ/ДОХ	0	0	0	0	0

Дүүргийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 826 хүн нас барсан байна. Нийт нас баралтын дотор нялхсын эндэгдэл 40 (4.8%) байна. Нийт төрсөн эх 3711 нь өмнөх оны мөн үеэс 2 (0.05%), амьд төрсөн нярайн тоо 3733 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 (0.1%)-аар тус тус буурсан байна.


Зураг 4. Нас баралт, нялхсын эндэлдлийг харьцуулахад, 2011-2018 он



Зураг 5. Төрсөн эх, амьд төрсөн нярайг эндсэн эх, нялхсын эндэгдэлтэй харьцуулахад, 2011-2018 он



Зураг 6. Нийт төрөлт болон нас баралт, 2011-2018 он



Шалтгаан нь олон хүчин зүйлээс хамаарч буй хэдий ч дараах голлох асуудал эх, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөг үзүүлсээр байна. Хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлж буй үндсэн асуудлууд:

- Агаарын бохирдол маш их
- Хүнс болон үндны усны бохирдол
- Орчны бохирдол
- Хүүхдийн төлөвшил, дадал хэвшил, эцэг эхийн хариуцлага сул
- Нийгмийн болон амьжиргааны байдал
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн асуудал орхигдох, тусламж, үйлчилгээний хүртээмжгүй байдал
- Боловсрол, эрүүл мэндийн байгууллагын хүрэлцээ, ачаалал гэх мэт


Эдгээр асуудал байгаа болохоор хүүхдийн өвчлөл, ялангуяа амьсгалын замын өвчлөл хурдацтай нэмэгдэж байна. 0-15 насны хүүхдийн өвчлөлийн шалтгааны авч үзвэл 2018 онд нийт 17518 хүүхэд халдварт болон халдварт бус өвчнөөр өвчилснөөс:

1. Амьсгалын замын өвчлөл - 10858
2. Шүд, амны өвчлөл - 1891
3. Чих, хамар, хоолой, нүдний өвчлөл – 1467
4. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл- 1167
5. Арьсны замын эмгэг- 728
6. Халдварт өвчин - 654
7. Бусад өвчлөл – 753 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 6. Хүүхдийн өвчлөл, насны ангиллаар, 2018 он

№	Өвчлөл	Нийт	0-5 нас	6-10 нас	11-15 нас
1	Амьсгалын замын өвчлөл	10 858	8 732	1 378	748
2	Шүд, амны хөндийн өвчлөл	1 891	746	760	385
3	Нүд, чихний өвчлөл	1 467	893	348	226
4	Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл	1 167	928	136	103
5	Арьсны замын эмгэг	728	474	132	122
6	Халдварт өвчин	654	148	316	190
7	Бусад өвчлөл	753	389	152	212
	Нийт дүн	17 518	12 310	3 222	1 986

Зураг 7. Хүүхдийн өвчлөл, насны ангиллаар, хувиар, 2018 он




Хүүхдийн өвчин тусах тохиолдол эрс нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд нийт өвчлөлийн 62.0 хувийг амьсгалын замын өвчлөл (ханиад, томуу, хатгаа г.м) эзэлж, шүдний өвчлөл 10.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 7. Хүүхдийн өвчлөл, хороодоор, 2018 он

Хороо	Амьсгалын замын өвчлөл	Шүд, амны хөндийн өвчлөл	Нүд, чихний өвчлөл	Хоол боловсруулах	Арьсны замын эмгэгийн өвчлөл	Халдварт өвчин	Бусад өвчлөл	Нийт өвчлөл
1-р хороо	86	13	28	8	17	10	12	174
2-р хороо	119	35	21	5	22	19	11	232
3-р хороо	218	31	33	24	16	16	10	348
4-р хороо	182	28	26	7	22	15	10	290
5-р хороо	201	32	39	11	26	19	13	341
6-р хороо	128	58	69	10	36	28	20	349
7-р хороо	913	136	103	135	70	63	44	1 464
8-р хороо	295	56	20	6	12	9	7	405
9-р хороо	773	114	67	52	43	36	30	1 115
10-р хороо	455	97	98	42	43	43	38	816
11-р хороо	321	48	44	119	24	25	19	600
12-р хороо	1 503	145	163	152	79	64	70	2 176
13-р хороо	1 405	158	159	143	70	33	67	2 035
14-р хороо	196	77	56	28	35	29	45	466
15-р хороо	327	230	89	19	33	35	46	779
16-р хороо	956	267	175	74	74	71	117	1 734
17-р хороо	680	120	103	61	41	45	76	1 126
18-р хороо	919	99	79	145	33	41	63	1 379
19-р хороо	1 181	147	95	126	32	53	55	1 689
Нийт дүн	10 858	1 891	1 467	1 167	728	654	753	17 518

Зураг 8. Хүүхдийн өвчлөл, хороодоор, 2018 он



ДҮГНЭЛТ

Чингэлтэй дүүрэгт 2018 онд төрийн нэгдсэн 1, өрхийн эрүүл мэндийн 16 төв нийт 19 нэгжид 208 эмч, ажилтнууд ажиллаж, дүүргийн иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. Эмнэлгийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг Төв эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг, Бага тойруу салбар, Хүүхдийн амбулатори, Хайлааст салбаруудаар дамжуулан хүргэж байгаа бөгөөд эдгээрт 357 эмч, ажилтан албан хаагчид ажиллаж байна.

Дүүргийн иргэдэд эрүүл мэндийн салбарын үйлчилгээг 17 эмнэлгийн байгууллагын 565 мэргэжилтнүүд үзүүлсэн байна. Тухайлбал, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн 24, эм зүйч 3, их эмч 177, сувилагч 187, эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан 35, мэдээллийн технологийн инженер 4, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер 2, бусад дээд мэргэжилтэн 28, бусад ажилтан 98 ажиллаж, ард иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлжээ.

Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 690546 үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30837 (4.3%)-аар буурсан байна. Нийт бүртгэгдсэн өвчлөл 37510 байгаагаас нийт халдварт өвчин 2061 (5.5%) –г эзэлж байна. Дүүргийн хэмжээнд төрсөн эх 3711 нь өмнөх оны мөн үеэс 2 (0.05%), амьд төрсөн нярайн тоо 3733 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 (0.1%)-аар тус тус буурсан байна. Харин 826 хүн нас барсан ба нийт нас баралтын дотор нялхсын эндэгдэл 40 (4.8%) эзэлж байна.

Шалтгаан нь олон хүчин зүйлээс хамаарч буй хэдий ч дараах голлох асуудал эх, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөг үзүүлсээр байна. Хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлж буй үндсэн асуудлууд:

- Агаарын бохирдол маш их
- Хүнс болон ундны усны бохирдол
- Орчны бохирдол
- Хүүхдийн төлөвшил, дадал хэвшил, эцэг эхийн хариуцлага сул
- Нийгмийн болон амьжиргааны байдал
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн асуудал орхигдох, тусламж, үйлчилгээний хүртээмжгүй байдал
- Боловсрол, эрүүл мэндийн байгууллагын хүрэлцээ, ачаалал гэх мэт

Эдгээр асуудал байгаа болохоор хүүхдийн өвчлөл, ялангуяа амьсгалын замын өвчлөл хурдацтай нэмэгдэж байна. 0-15 насны хүүхдийн өвчлөлийн шалтгааны авч үзвэл 2018 онд нийт 17518 хүүхэд халдварт болон халдварт бус өвчнөөр өвчилсөн.

Манай дүүргийн хувьд гэр хороололд өвчлөлийн түвшин өндөр байгаа төдийгүй нийт өвчлөлийн 62.0 хувийг амьсгалын замын өвчлөл (ханиад, томуу, хатгаа г.м) эзэлж, шүдний өвчлөл 10.8 хувийг эзэлж байна. Эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг хамгийн чухлаар авч үзэж буй хэдий ч сүүлийн жилүүдэд хүүхдийн эндэгдэл, өвчлөл, бусад эрүүл мэндийн үзүүлэлт нь төдийлөн сайжрахгүй байгаа нь үзүүлэлтүүдээс харагдаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

АЖИЛЛАГЧДЫН ТОО

565

Эмэгтэй
494 (87%)



Эрэгтэй
71 (13%)



Нийт их эмч

177



Бусад ажилчид

388



Эрүүл мэндийн ажиллагчдын 177 их эмч байгаагаас анхдагч шатлалын эмнэлэгт буюу өрхийн эрүүл мэндийн төвд 78, хоёрдогч шатлалын эмнэлэгт буюу дүүргийн нэгдсэн эмнэлэгт 99 хүн ажиллаж байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

Нийт үзлэг

2018 690546
2017 721383



Дүүргийн эмнэлэгт

2018 248210
2017 241737



Өрхийн эмнэлэгт

2018 442336
2017 479646



Амаржсан эх



2018 3711
2017 3713

Төрсөн хүүхэд




2018 3733
2017 3738

Хэвтэн эмчлүүлсэн



2018 10908
2017 10469

Халдварт өвчин



2018 2061

2613

Нас баралт

2018 826
2017 762



Нялхсын эндэгдэл

2018 40
2017 24

